



АМЬТНЫ МУЗЕЙН ТАНИЛЦУУЛГА



Тул загас



Шонхор



Аргаль



Чоно



Хар сүүлт



**ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ,
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ**



Утас: 70107644



**И-мэйл: tsengegusnuuts@gmail.com
Вэб сайт: www.ecc.gov.mn**



**Монгол улс, 17023
Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг 11 хороо, Зайсан 9,**



АМЬТНЫ МУЗЕЙД УРЬЖ БАЙНА

“Мянга сонсохоор нэг үз” гэсэн үгтэй.

БОАЖЯ-ны харьяа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн музейн биет үзмэрүүд нь амьтдыг бодит биетээр нь, мэргэжлийн хүний тайлбартай үзэх боломжийг олон нийтэд олгож, улмаар байгаль орчноо танин мэдэх, биологийн олон янз байдлын ач холбогдлыг ойлгуулах чухал ач холбогдолтой юм.

Амьтан бүр амьд байгальд өөрийн давтагдашгүй үүргийг гүйцэтгэдэг учраас хүн төрөлхтөн янз бүрийн арга, хэлбэрээр хайрлан хамгаалж иржээ. Эдгээр арга хэлбэрийн нэг нь сурталчлан таниулах юм. Жилд 12-20 мянга орчим хүүхэд, залуус ЦУНБХТ-ийн музейгээр үйлчлүүлж, байгаль орчны танин мэдэхүйн мэдлэгээ дээшлүүлдэг. Эндээс тус музей байгаль орчин, амьтдаа сурталчлан таниулах, хайрлан хамгаалах мэдлэг, хандлага суулгахад томоохон үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагдаж байна. Японы “Жайка” байгууллагаас музейн үзмэрийн танхим бүхий байгаль орчны сургалт, судалгаа, мэдээллийн төвийн барилгыг барьж байгуулж өгсөнд талархах нь зүй.

Монгол орны амьтны төрөл, зүйлүүдээс ЦУНБХТ-ийн музейд 4 зүйлийн хөхтөн, 6 зүйлийн загас, 2 зүйлийн мөлхөгч, 4 зүйлийн хоёр нутагтан, 15 зүйлийн шувууны чихмэл, 20 зүйлийн шавжны биет үзмэр бий. Нэг үгээр, Монгол орны амьтны аймгийн зүйл бүрийг төлөөлөхүйц биет үзмэр байна.

Тус музей нийтдээ 150 орчим үзмэртэй. Эдгээр үзмэрүүдээс төлөөлүүлэн товч танилцуулгыг бэлтгэн хүргэж байна.

Та бүхэн манай музейгээр үйлчлүүлээрэй. Байгаль орчны талаарх мэдлэг тань нэмэгдэж, гоо үзэсгэлэнтэй, сүрлэг ихэмсэг амьтдын биет үзмэрүүдээс үзэсгэлэнт байгалиа тольдон харж, хайрлан хамгаалах урам зориг тань нэмэгдэх болно.

Захирал

Т.Бүдээхүү

ЦУНБХТ-ИЙН МУЗЕЙ 8 ЗҮЙЛИЙН ХӨХТНИЙ БИЕТ ҮЗМЭРТЭЙ

Дэлхийд 1229 төрлийн, 153 овог, 29 багийн 5400 гаруй зүйл хөхтөн амьтад тархсан байдаг. Эдгээрээс хамгийн жижиг нь гахайн хамарт сарьсан багваахай ба биеийн жин нь ердөө л 1.4 грамм. Хамгийн том нь хөх халим бөгөөд биеийн жин нь 150 тонн, биеийн урт нь 30 метр юм. Хөхтөн нь сээр нуруутан амьтдын хүрээ бөгөөд эмэгчин нь хөх, сүүний булчирхайтай. Эр, эм хоёул үс, хөлсний булчирхайтай, дунд чихний яс зэрэгтэй болно. Гэхдээ хуурай газрынх ч бай, усных ч бай бүх хөхтөн амьтад адилхан халуун цустай.

Иймээс хөхтөн амьтад дэлхийн ямар ч уур амьсгалтай газар амьдрах чадвартай. Биеийн гадна хэсэг үсээр хучигдсан, үр төлөө сүүгээрээ хооллодог амьтдыг хэлнэ.

Монгол орны амьтны аймагт 140 гаруй зүйлийн хөхтөн бий. “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн музейд 8 зүйл хөхтний биет үзмэр байдаг.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ДЭЛХИЙД МОНГОЛ НЭРЭЭР БҮРТГЭГДСЭН АРГАЛЬ

**МОНГОЛ НЭР: АРГАЛЬ
ДЭЛХИЙД: ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ
БҮС НУТАГТ: УСТАЖ БОЛЗОШГҮЙ
СТАТУСТАЙ**

**ЛАТИН НЭР: OVIS AMMON /LINNAEUS, 1758/
АНГЛИ НЭР: ARGALI**

1. Монголын аргаль бусдаас биеэр хамгийн том, дэлхийд нэн ховордсон амьтан юм.
2. Дэлхий нийтэд АРГААЛЬ буюу ARGALI гэж монгол нэршлээр бүртгэгдсэн амьтдын нэг.
3. Биеийн ерөнхий төрхөөр монгол хоньтой төстэй боловч байгальд зохицож хөл нь өндөр зэгзгэр, үс ноос нь тачир, жижиг годгор сүүлтэй байдаг.
4. Афганистан, Хятад, Энэтхэг, Казахстан, Киркистан, Монгол, Балба, Пакистан, ОХУ, Тажикистан, Узбекистаны нутагт тархсан.
5. Монгол орны аргалийн тоо толгой 1975 онд 50 мянга байсан бол 2001 онд 13-15 мянга болж буурсан мэдээ гарсан.
6. Эмийг хомь, төлийг хурга, эрийг угалз гэдэг. Байгалийн нөхцөлд 10-13 жил насалдаг.
7. Маш том угалзарсан эвэр нь 25 кг хүртэл жинтэй, 190 см хүртэл урт болдог.
8. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, уул уурхай, бэлчээрийн хомсдол, малын тооны өсөлт, хууль бус ан, амьдрах орчны доройтол зэргээс тоо толгой багассан.
9. 2000 онд Амьтны тухай хуулиар “нэн ховор” гэсэн ангилалд оруулсан, 2006 онд Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны Улаан номын “устах аюул нүүрлэсэн” гэсэн ангилалд оруулсан.
10. Засгийн газрын тогтоолоор аргалийн экологи-эдийн засгийн үнэлгээг 23 сая төгрөгөөр тогтоосон. Хууль бусаар агнаж, барьсан тохиолдолд уг үнэлгээг 2 дахин нугалж төлдөг хуультай.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ХОСТОЙГОО НАСАН ТУРШ ХАМТ АМЬДАРДАГ СААРАЛ ЧОНО

МОНГОЛ НЭР: СААРАЛ ЧОНО
СТАТУС: ДЭЛХИЙ: ЭМЗЭГ
БҮС НУТАГ: ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ

ЛАТИН НЭР: CANIS LUPUS /LINNAEUS, 1758/
АНГЛИ НЭР: GREY WOLF

1. Судалгааны дүнд саарал чоно гэрийн нохойтой гарал нэгтэй болох нь тогтоогджээ.
2. Чоно бол экосистемдээ хамгийн дээд түвшний махан идэштэн бөгөөд орчиндоо амархан дасан зохицох чадвартай.
3. Дунджаар байгальд 4 - 6 жил амьдрах бөгөөд бадриун зэгзгэр мөчтэй. Биеийн урт 105-160 см, сүүлний урт 35-50 см, биеийн жин 80 кг хүрдэг.
4. Хоргодоц сайтай хад асга бүхий өндөр уул, ой тайга, цөл хээрт амьдрах бөгөөд зэрлэг туурайтан амьтан, малын байршил дагаж улирлаар байршлаа сэлгэнэ.
5. Хоол тэжээл ховордсон үед гэрийн мал, мэрэгчид, жижиг шувуу, өндөг, ангаахай, загас, амьтны сэг зэм, ургамлын үр жимсээр хооллоно.
6. Богино зайд 38-56 км/цаг хурдтай давхиж чаддаг. Мөн нам гүм үед чоно 9-16 км-ын цаадах чимээг сонсох чадвартай.
7. Чоно нэгэнт л хос болж бүл үүсгэсэн бол насан туршдаа хамт амьдарч, бэлтрэгнүүдийн хамтаар цөм сүрэг үүсгэнэ. Нас бие гүйцсэн сүргийн бүх гишүүд тэргүүлэгч хосынхоо бэлтрэгнүүдийг асарч халамжлах үүрэгтэй.
8. Саарал чоног олноор нь устгавал байгалийн тэнцвэрт байдал алдагдаж, мал амьтны гаралтай өвчин тархах аюул нүүрлэдэг.
9. Чоно барьсан малынхаа сэвстэй гүзээг хэзээ ч хөндөж хагалдаггүй гэдэг. Учир нь үүр ноохойд нь аюул тулгарахад бэлтрэгээ гүзээнд хийж зөөхийн тулд гэнэ.
10. Саарал чононы экологи-эдийн засгийн үнэлгээг 1 сая 200 мянган төгрөгөөр тогтоосон. Хууль бусаар агнаж, барьсан тохиолдолд энэ үнэлгээг 2 дахин өсгөж төлөх хуультай.



**НОХОЙ ЗЭЭХИЙН
ТУХАЙ 10 БАРИМТ**

“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ЭР ЗОРИГИЙН БЭЛГЭДЭЛ НОХОЙ ЗЭЭХ

**МОНГОЛ НЭР: НОХОЙ ЗЭЭХ
ДЭЛХИЙД: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
БҮС НУТАГТ: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ**

ЛАТИН НЭР: GULO GULO /LINNAEUS, 1758/

АНГЛИ НЭР: WOLVERINE

1. Суусарын төрөлд багтдаг нохой зээхийг латинаар “Gulo gulo” гэдэг. Энэ нь идэмхий, ховдог гэсэн утгатай үг.
2. Нас бие гүйцсэн нохой зээх нь дунд зэргийн хэмжээний нохойтой ойролцоо биетэй, 65-87 см урт, 17-26 см сүүлтэй, 12-31 кг жинтэй байна. Зулзагыг бөртөн гэдэг.
3. Нохой зээх нь өөрөөсөө 5 дахин том амьтныг, жишээлбэл хандгайг агнах чадвартай.
4. Маш их зоригтой, юунаас ч айдаггүй учраас нохой зээхийг эр зоригийн бэлгэ тэмдэг ч гэдэг.
5. Зузаан, тослог, бараан арьс нь хүйтнээс сайн хамгаалдаг. Гол зэвсэг нь хүчирхэг эрүү, хурц шүд, бахим сарвуу, хурц хумс, арга ухаан юм.
6. “Тайгын мангас” гэгддэг нохой зээх ганцаараа том хэмжээний газарт тэнүүчлэн амьдарна. Бие гүйцсэн нэг нохой зээхийн эзэмшил нутаг 1500 ам дөрвөлжин км ба түүнээс дээш. Тусгай үнэртэн ялгаруулж газар нутгийнхаа хил хязгаарыг тогтоодог.
7. Элдэв идэшт махчин. Мэрэгч, туруутан, шувууны өндөг, авгалдай, жимс, жимсгэнээр хооллоно. Өвөл үнэрлэх мэдрэмжээ ашиглан үхсэн амьтны сэг зэмийг цасан доороос ч ухаж иддэг.
8. Зассан үүрэндээ ихэвчлэн 2-3 бөртөн гаргана. Байгальд 8-10 хүртэл насална.
9. Нохой зээхийн эрүү маш хүчирхэг булчинтай, хазалтын хүч 1720 PSI байдаг. Хүн, амьтны зуулт буюу хазалтын хүчийг PSI гэх хэмжүүрээр хэмждэг бөгөөд насанд хүрсэн хүний хазалтын хүч 100-150 PSI байдаг ажээ.
10. Нохой зээхийн хойд хөл нь урд хөлнөөсөө урт байдаг. Болхи харагддаг ч олз руу дайрахдаа цагт 50 км хурдалж чаддаг байна.



**ОЙН БУЛГАНЫ
ТУХАЙ 10 БАРИМТ**

“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ЭЛДЭВ ИДЭШТЭН ОЙН БУЛГА

**МОНГОЛ НЭР: ОЙН БУЛГА
ДЭЛХИЙД: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
БҮС НУТАГ: ЭМЗЭГ СТАТУСТАЙ**

**АНГЛИ НЭР: SABLE
ЛАТИН НЭР: MARIES ZIBELLINA /LINNAEUS,
1758/**

1. Оросын Уралын нуруунаас Сибирь, Монголын хойд хэсэг, Хятад, Японд тархсан ойн булга нь манай бүс нутагт эмзэг статустай амьтанд тооцогдсон.
2. Суусарын хамгийн ойрын төрөл үслэг хөвсгөр энэ амьтан гоёмсог арьснаасаа болж ан агнуурт олноор өртдөг. Үслэг эдлэлийн зах зээл дэх арьсны ихэнх нь булганы фирмээс нийлүүлэгддэг байна.
3. Сунасан, нарийхан бие нь 40-60 см урт, 2 кг орчим жинтэй. Маш бутлаг сүүл нь амьтны биеийн уртын гуравны нэгийг эзэлдэг.
4. Биеийн өнгө газар зүйн бүс бүслүүрээс шалтгаалан харилцан адилгүй.
5. Уулын шилмүүст болон холимог ойн унанги мод ихтэй гүн тайга, хөвчид амьдардаг.
6. Хоногийн турш идэвхтэй, өдөр шөнийн амьдралтай. Хааяа өдрийн цагаар ч гөрөөлнө.
7. Идшиндээ ойн төрөл бүрийн жижиг мэрэгчид, туруутан амьтад, туулай, хэрэм, шувуу, сээр нуруугүй амьтдаас гадна самар, жимсээр ч хооллодог элдэв идэштэн амьтан.
8. Хээлээ 260-280 хоног тээгээд модны хонгилд 3-4, хааяа 7 хүртэл тооны хойв төрүүлнэ.
9. Экологи- эдийн засгийн үнэлгээг 600,000 төгрөгөөр тогтоосон. Хууль бусаар агнаж, барьсан тохиолдолд дээрх үнэлгээг 2 дахин өсгөж төлөх хуультай.
10. 1953 оноос хойш агнахыг хориглосон. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтнаар бүртгэгдсэн. Тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагддаг.

ШИЛҮҮСНИЙ ТУХАЙ 10 БАРИМТ

МИЙГИЙН ОВГИЙН ШИЛҮҮС

МОНГОЛ НЭР: ШИЛҮҮС
CITES- КОВЕНЦИЙН ХАВСРАЛТ: I
ДЭЛХИЙД: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
БҮС НУТАГТ: ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ
СТАТУСТАЙ

ЛАТИН НЭР: LYNX LYNX /LINNAEUS, 1758/
АНГЛИ НЭР: EURASIAN LYNX

1. Мийгийн овгийн шилүүс нь биеийн хэмжээгээр ирвэсний дараа орно. Биеийн урт нь 106-130 см, өндөр нь 60-70 см, амьдын жин нь 25-30 кг бөгөөд чихний урт нь бараг 10 см байдаг.
2. Богино сүүлтэй, чихнийхээ үзүүрт туг хар үстэй байдгаараа өвөрмөц. Цасан дээр явахад зохилдсон том хавтгай тавхайтай.
3. Шилүүсний тоо толгой нь түүний хоол, тэжээл болох амьтдын тоо толгойтой шууд хамааралтай байдаг. Идэш бологч амьтад элбэг байвал шилүүсний тоо толгой ч дагаад нэмэгддэг гэсэн үг.
4. Бүрэнхий шөнөөр идэвхтэй амьдралтай шилүүс ганц нэгээрээ амьдарна. Шээсээрээ мод шүрших, хөлөөрөө газар, модны их биеийг хусах зэргээр өөрийн амьдрах нутаг дэвсгэрээ тэмдэглэдэг.
5. Туулай, чандага, бор гөрөөс, хүдэр, хар сүүлт зээр, янгирын ишиг, аргалийн хурга, тарвага, жижиг мэрэгчид болон дунд зэргийн биетэй шувуудаар хооллоно.
6. Шувууг 1.8 метр өндөрт үсэрч барьж авдаг чадвартай.
7. Тайга, холимог ой, ойт хээр, хээрийн хад чулуут уулс, өндөр уулархаг нутаг, говь, цөлийн хадат уулсаар тархсан.
8. Эм шилүүс 2-3 ногуул төрүүлнэ. Байгальд 17-24 жил насална.
9. Сүүлийн 10 жилийн хугацаанд шилүүсний тоо толгой 630-аас 1300-гийн хооронд байгаа судалгаа гарсан.
10. Шилүүсний экологи-эдийн засгийн үнэлгээг 2 сая 600 мянган төгрөгөөр тогтоосон. Хууль бусаар агнах, барьсан тохиолдолд экологи - эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж төлөх хуультай.

ЯНГИРЫН ТУХАЙ 10 БАРИМТ



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ЦООХОР ИРВЭСНИЙ ХҮНС-ЯНГИР ЯМАА

МОНГОЛ НЭР: ЯНГИР
ДЭЛХИЙД: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД: ХОВОРДОЖ
БОЛЗОШГҮЙ

ЛАТИН НЭР: CAPRA SIBIRICA/PALLAS, 1776/
АНГЛИ НЭР: SIBERIAN IBEX

1. Дэлхий дээр 8 зүйлийн зэрлэг ямаа байдгийн нэг нь янгир ямаа юм.
2. Нас гүйцсэн эрийг нь тэх, эмийг нь мэгж, төлийг нь ишиг гэнэ.
3. Тэхийн биеийн урт 128-167 см, сэрвээгээрээ 90-105 см өндөр, жин 80-110 кг хүрнэ. Тэх гэдэргээ махийсан 120 см орчим урт эвэртэй.
4. Янгирыг 2006 онд Монгол орны амьтдын “Улаан данс” номонд “ховор болон ховордож болзошгүй” зэрэглэлээр оруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны хавсралтад бүртгэсэн.
5. Монгол орны янгирын тоо толгой 1980 оны эхээр 80 орчим мянга байсан бол 2009 онд хийсэн судалгаагаар 36 мянга болж буурсан.
6. Янгир нь ихэвчлэн сүрэглэн амьдардаг. Улирал, бэлчээрийн төлөв байдал, ороо нийллэгээс хамааран 3 – 40 хүртэлх тоо толгойгоор сүрэглэнэ.
7. Байгалийн нөхцөлд 10-22 жил насалдаг.
8. Янгир ямаа нь цоохор ирвэсний хамгийн гол хоол тэжээл юм.
9. Афганистан, Хятад (Шинжаан), баруун хойд Энэтхэг, зүүн өмнөд Казахстан, Киргизстан, Тажикистан, Узбекистан, Монгол, Пакистаны хойд хэсэг, Оросын өмнөд хэсэгт тархсан.
10. Засгийн газрын тогтоолоор янгирын экологи-эдийн засгийн үнэлгээг 5 сая 300 мянган төгрөгөөр тогтоосон. Хууль бусаар агнаж, барьсан тохиолдолд уг үнэлгээг 2 дахин нугалж төлдөг хуультай.



ГОВИЙН ГАЙХАМШИГТ АМЬТАН- ХАР СҮҮЛТ ЗЭЭР

**МОНГОЛ НЭР: ХАР СҮҮЛТ ЗЭЭР
ДЭЛХИЙД: ЭМЗЭГ
БҮС НУТАГТ: ЭМЗЭГ СТАТУСТАЙ**

**ЛАТИН НЭР: GOITERED GAZELLA
АНГЛИ НЭР: BLACK-TAILED GAZELLA**

1. Эрийг ооно, эмийг шаргачин, төлийг янзага гэнэ. Оонын биеийн урт 110-116 см, шаргачингийнх 93- 110 см байх бол ооно 23-33 кг, шаргачин 18-20 кг жинтэй байна.
2. Нэг газар удаан амьдардаггүй, бэлчээрийн соргогийг даган хэдэн арван км нүүдэллэн амьдардаг.
3. Сонсгол нь маш сайн, ямар нэгэн аюул тулгарвал гэнэт байрнаасаа хөөрч, сүүл хараагаа дээш өргөж цойлон хөлийн хурдаар зугатдаг. Цагт 55-62 км хурдалдаг.
4. Хүн, чоно хоёр хар сүүлт зээрт хамгийн их аюул учруулдаг. .
5. 2021 оны судалгаагаар Монгол орны хэмжээнд 73 мянган хар сүүлт зээр тоологдсон нь дэлхий дээрх нийт хар сүүлт зээрийн 80 хувь нь юм.
6. Амт чанар сайтай мах, арьсанд нь болж хулгайгаар их агнадаг. Нутагладаг газарт нь малын тоо толгой олшрох нь зээрийн бэлчээр нутгийг хомсдуулах хүчин зүйл болдог.
7. Монгол Улсад хар сүүлт зээр агнахыг 1965 оноос хуулиар хориглосон. Засгийн газрын 2001 оны 264-р тогтоолоор ховор амьтны зэрэглэл, хөхтөн амьтны Улаан дансанд тус тус бүртгэсэн.
8. Хар сүүлтийн тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтад хамрагдсан.
9. Хар сүүлт зээрийн экологи-эдийн засгийн үнэлгээ 3 сая 300 мянга. Хууль бусаар барьж, агнасан тохиолдолд үнэлгээг 2 дахин нугалж төлөх хуультай.
10. Монголын говь цөлийн төлөөлөл болсон гайхамшигт 6 амьтны нэг бол хар сүүлт зээр юм.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ЗАЛЫТ ШАР САГСГАР СҮҮЛЭЭРЭЭ ТЭНЦВЭРЭЭ ОЛДОГ

**МОНГОЛ НЭР: ШАР ҮНЭГ
ДЭЛХИЙД: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
БҮС НУТАГТ: АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
СТАТУСТАЙ**

**ЛАТИН НЭР: VULPES VULPES/
LINNAEUS, 1768/
АНГЛИ НЭР: RED FOX**

1. Шар үнэг бол халуун бүсээс эхлээд хойд туйл хүртэлх цаг уурын янз бүрийн нөхцөлд амьдрах чадвартай, гайхалтай авъяаслаг хөхтөн амьтан юм.
2. Өвлийн үс улаан шаргал, зуны үс цайвардуу саарал өнгөтэй. Биеийн урт 70-90 см, сүүлний урт 40-60 см, чихний урт 9-11см, биеийн жин 5-10 кг.
3. Монголчууд “үнэгэн харанхуй” гэж ярьдаг нь үнэгний шөнийн амьдралтай холбоотой гарсан хэлц үг. Шөнөжингөө зогсолтгүй хурдан гүйж, 40 орчим янзын дуу авиа гаргаж чаддаг.
4. Сүүл нь биеийн тэнцвэр олох, хүйтэнд дулаан хадгалах, дээш өргөж бие биедээ мэдээлэл дамжуулах чухал үүрэгтэй.
5. Үлгэрт заль мэхтэй дүрээр ихэвчлэн үнэгийг төлөөлүүлдэг нь ангаа барихдаа болон анчдаас зугатахдаа сагсгар том сүүлээрээ хуурч чаддагтай холбоотой.
6. Нэг метр зузаан цасны доор хулгана байгааг сонсож, үнэрлэж чаддаг.
7. Жилд нэг удаа төллөх бөгөөд дунджаар 4-6 гавар төрүүлнэ. Аав, ээж үнэгнүүд гавараа том болтол халамжилж өсгөдөг гэр бүлсэг амьтан.
8. Туулай, шавж, загас, шувуу, өндөг, жижиг мэрэгчид гэх мэтээр хооллодог махчин амьтан. Үнэгний нэг гэр бүл хоногт хэдэн арван жижиг мэрэгчдийг иддэг
9. “Амьтны тухай” хуулиар элбэг амьтанд тооцогдоно. Жил бүрийн 2 дугаар сарын 11-нээс 11 дүгээр сарын 20 хүртэлх хугацаанд агнахыг хориглосон.
10. Үнэгний экологи-эдийн засгийн үнэлгээ 220 мянган төгрөг. Хууль бусаар барьж, агнавал уг үнэлгээг 2 дахин нугалж төлдөг хуультай.

ЦУНБХТ-ИЙН МУЗЕЙ 15 ЗҮЙЛИЙН ШУВУУНЫ БИЕТ ҮЗМЭРТЭЙ

Монгол орны амьтны аймагт нийт 510 гаруй зүйлийн шувуу бий. Эдгээрээс 15 зүйлийн шувууны биет үзмэр “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн музейд байдаг. Шувуудын үзмэрийг төлөөлүүлэн Үндэсний бахархалт шувуу шонхорын 3 зүйл, хамгийн том махчин шувуу ёл, хамгийн хүчирхэг махчин шувуу цармын бүргэд, эмчилгээний чанартай махнаасаа болж ховордсон Алтайн хойлог, тогос шиг гоёмсог нургийн сойр, ойн эмч гэгддэг тоншуул шувуудын талаар танилцуулья.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...



Үндэсний бахархалт шонхор шувуу

Дэлхий дээр 60 орчим зүйлийн шонхор шувуу байдгаас Монголд 10 зүйл нь бийг судлаачид тогтоожээ. Харин ЦУНБХТ-ийн ан амьтны музейд идлэг шонхор, начин шонхор, шууман шонхор гэсэн 3 зүйл шонхорын биет үзмэр байна. 2012 онд их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газраас шонхор шувууг үндэсний бахархалт шувуугаар зарласан. Шонхор шувууг Монголын ард түмний эрч хүч, эрх чөлөө, эв нэгдэл, байгаль дэлхийгээ хайрлах үзлийн бэлгэдэл хэмээн ийнхүү зарласан. Эрт дээр үеэс монголчууд шонхор шувууг эр зориг, сүр хүчний бэлгэ тэмдэг болгон дээдэлж ирсэн түүхтэй. Шонхор шувууд том, жижиг мэрэгч, шавж зэргээр хооллож, тэдний тоо толгойг зохицуулах үүрэг гүйцэтгэдэг.

“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...



ИДЛЭГ ШОНХОР

ЛАТИН НЭР: FALCO CHERRUG

АНГЛИ НЭР: SAKER FALCON

Шонхруудаас хамгийн том биетэй нь идлэг шонхор. Монголд ирж өндөглөдөг нүүдлийн шувуу. Монгол орныг идлэг шонхор шувууны үржлийн голлох том популяци хэмээн судлаачид үздэг. Цагт 320 км хүртэл хурдтайгаар нисэж, шумбах чадвартай, хүнээс 2.6 дахин нарийвчлалтай хардаг. Өөрөө үүр засдаггүй, бусдын үүрийг ашигладаг шувуу.

“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...



НАЧИН ШОНХОР

ЛАТИН НЭР: FALCO TINNUNCULUS

АНГЛИ НЭР: EURASIAN KESTREL

Өвөл, зунгүй суурин байдаг шувуу юм. Өндөр уулын тагаас бусад Монголын газар нутагт хааяагүй тархсан. Хад цохио, мод, байшин барилгын нүхэнд үүр засах ба хэрээний хуучин үүрийг хэрэглэх нь олонтаа.

“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...



ШУУМАН ШОНХОР

ЛАТИН НЭР: FALCO SUBBUTEO

АНГЛИ НЭР: EURASIAN HOBBY

Нүүдлийн шувуу. Томхон шавж, сарьсан багваахай зэргээр хооллоно. Дээд тал нь цагт 160 км хүртэл шунгаж хурдалдаг. Нарийхан урт, шувтан далавчтай учраас монголчууд шууман шонхор гэж нэрлэжээ. Жижиг биетэй энэ шувуу нүүдэллэн явсаар Африкт өвөлждөг ажээ.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ХҮРШГҮЙ ӨНДӨРТ ДҮҮЛЭН НИСДЭГ ЁЛ ШУВУУ

АНГЛИ НЭР: LAMMERGEIER, BEARDED VULTURE ЛАТИН НЭР: GYPAETUS BARBATUS

1. Ёл нь зөвхөн Төв Азид далайн түвшнээс дээш 1.500-3.000 метрийн өндөрт амьдардаг ховор шувуу юм.
2. Монголын Улаан номонд бүртгэгдсэн хамгийн том махчин шувуу ёлыг монголчууд "Ооч Ёл" хэмээн нэрлэдэг. Түүний хошууны хажуугаар ургасан хэсэг өд нь ооч сахал шиг харагддаг тул ооч ёл гэдэг нэртэй болжээ.
3. Биеийнх нь нийт урт 95-125 см атлаа далавчаа дэлгэхэд 3 метр орчим хэмжээтэй болж томордог том махчин шувуу.
4. Ёл шувуу ихэвчлэн амьтны яс, чөмөг иддэг. Томхон хэмжээний ясыг 100-150 метрийн өндрөөс чулуун дээр унагаан хагалж иддэг бөгөөд залуу ёл энэ аргыг 7 жилийн шаргуу хөдөлмөрөөрөө сурдаг ажээ.
5. Ёл шувуу нь мөнгөлөг туяа бүхий өргөс шиг хурц өдтэй, цагаан шаргал толгойтой бөгөөд зулай дээрх хар толбо, хошуун доор байрлах урт ооч сахал, шовх үзүүртэй далавч, зэв мэт сүүлээрээ бусад шувуудаас онцгой ялгарна.
6. Ёл нь бусад шувуудаас хамгийн өндөрт буюу 7500 метрийн өндөрт нисч чадахаас гадна алсын хараа маш сайн.
7. Ёл шувууг харьцангуй сэтгэл хөдлөл ихтэй гэдэг бөгөөд түүнийгээ нүдээрээ илэрхийлдэг. Ингэхдээ нүдэнд нь хурц улаан цагираг тодорч, уурсаж хилэгнэсэн үед нь цусан улаан болдог.
8. Хүчирхэг сүрдэм ёл шувууг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны долдугаар тогтоолоор ховор амьтнаар бүртгэжээ.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

ЦАРМЫН БҮРГЭД ХҮЧИРХЭГ ШУВУУ

АНГЛИ НЭР: GOLDEN EAGLE

ЛАТИН НЭР: AQUILA CHRYSÆTOS

1. Харцагынхан овгийн хүчирхэг махчин шувуудын нэг бол цармын бүргэд юм.
2. Ази, Европ, Хойт Америкийн нутгаар өргөн тархсан. Монгол Алтайгаас Их Хянганы баруун сэжүүр хүртэлх тайга, ойт хээр, хээр, говийн бүсийн далайн түвшнээс дээш 800-3000 метр хүртэл өргөгдсөн уул нуруу, хад цохио бүхий нутгаар байршдаг.
3. Биеийн урт нь 65-100 см урт байх бөгөөд далавчы дэлгэц 150-240 см, 2.5-7.0 кг жинтэй. Бүртгэгдсэн хамгийн том нь 102 см урт, 9 кг жинтэй байв.
4. Цармын бүргэд нь маш хурдан шунгаж нисдэгээрээ бусад бүргэдээс ялгарах ба цагт 241 км хүртэл хурдална.
5. Барих ангаа 2500-3500 метр өндөрт гарч хардаг. Өндөрт гарах тусам ангаа сайн олж харна.
6. Туулай, чандага, тарвага, зурам, үнэг, хулгана, суусар зэрэг хөхтөн амьтан, гургуул, ятуу, сойр гэх мэт шувуудыг барьж идэхээс гадна сэг зэмээр хооллодог.
7. Өндөр модны орой, өндөр байц хадан дээр өвс, мөчир зэргийг ашиглан хэд хэдэн үүр барьж сэлгэн амьдардаг. 155 хавтгай дөрвөлжин км орчим газрыг эзэмшин амьдардаг.
8. 3-4 нас хүрч байж үржилд орно. Цав цагаан эсвэл бор толботой өндөг гарах бөгөөд 40-45 хоног дарж дэгдээхий болгоно.
9. Цармын бүргэд 25-30 наслах бөгөөд эм нь эрээсээ урт насалдаг.
10. Казах түмэн цармын бүргэдийг сургаж, ан авд ашигладаг уламжлалтай.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АГНАХЫГ ХОРИГЛОСОН АЛТАЙН ХОЙЛОГ

АНГЛИ НЭР: ALTAI SNOWCOCK

ЛАТИН НЭР: TETRAOGALLUS ALTAICUS

1. Евразийн эх газрын урд хэсэг, Кавказын уулс, Гималайн нуруу, Төвөдийн өндөр уулсаар нутагладаг. Гималайн хойлогийг АНУ-ын Невада муж улсад шилжүүлэн нутагшуулж байна.
2. Монгол нутгийн далайн түвшнээс дээш 2700-3000 метр өндөрлөг уулсын оргил, байц цохио, ханан хад, нураг асгатай, энгэр, хажуу, хунх, нугачаа, хярын зоонд тархан амьдардаг.
3. Биеийн хэмжээ 30-40 см өндөртэй, 2.5-3.0 кг жинтэй.
4. Жил бүрийн 5-р сарын эхээр хад чулууны хоорондох нөмөр газар хонхойлж, хагд өвс, өд дэвсэж үүр засна. Мөн сарынхаа сүүлийн 8-12 хоногт цувуулан гаргасан өндгөө эмэгчин нь 28 хоног дарна.
5. Үетэн, холтсон цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн, буурцагтан ургамлаар голлон хооллоно. Өвөл арвай, улаан буудай, вандуй, шар будаа, овъёос, багсармал тэжээл иддэг.
6. Бүргэд, үлэг харцага, ирвэс, шилүүс, үнэг зэрэг махчин амьтдын идэш хоол болдог.
7. Сүргээрээ бэлчээрлэж, 1-2 нь харуулд гарах ба аюул тулгарвал харуул нь исгэрэн дохио өгснөөр сүргээрээ явгалан газрын өөд гүйдэг.
8. Хойлог нь 800 орчим эмийн ургамлын үндэс иддэг учраас махыг нь эмчилгээний чанартай хэмээн агнаж ашигладаг байсан.
9. Нисэхдээ муу, харин газрын өөд сайн гүйж чаддаг.
10. 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол Улсын Улаан номонд оруулсан.

ОЙН ЭМЧ-ХАР ТОНШУУЛ



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР: BLACK WOODPECKER
ЛАТИН НЭР: DRYOCOPUS MARTIUS

ХАР ТОНШУУЛЫН ТУХАЙ 8 БАРИМТ

1. Дэлхий дээрх 230 зүйлийн тоншуул шувууны 10 зүйл нь Монгол оронд байдаг. Эдгээрээс хамгийн том биетэй нь ой модтой уулс бараадан Монголд суурин амьдардаг хар тоншуул юм.
2. Хар тоншуулын биеийн урт нь 45-47 см, далавчны дэлгэц 64-78 см том болно.
3. Толгойн орой дээрх улаан залаанаас бусад бүх бие нь хар өнгөтэй. Урт том хошуу нь 6.3 см хүртэл урттай.
4. Ихэвчлэн улиас, нарс модонд үүрлэн 4 ба түүнээс дээш өндөг гаргадаг.
5. Мод тоншиход зориулагдсан зузаан гавлын яс, нүдэнд үртэс орохоос сэргийлсэн нэмэлт зовхитой.
6. Тоншуул нь модны холтос дотроос шавжны авгалдай цуглуулах тусгай хэлтэй. Хэл нь хошуунаасаа нэг дахин урт, уян хатан, төгсгөлдөө дэгээтэй.
7. Хатуу, шовх сүүлний өд нь хоол хайж модонд авирах үед түшиг тулгуур болдог.
8. Модыг 50 см хүртэл гүн цоолж дөнгөдөг тоншуул моддын шавж, авгалдайг түүж иддэг учраас ойн эмч гэдэг.

ТОГОС ШИГ ГОЁМСОГ НУРГИЙН СОЙР



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР: BLACK-BILLED CAPERCAILLIE
ЛАТИН НЭР: TETRAO UROGALLOIDES

НУРГИЙН СОЙРЫН ТУХАЙ 7 БАРИМТ

1. Монгол орны суурин, тахианы багийн шувуудаас биеэр хамгийн том шувуу юм.
2. Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулсын ой тайгын хуш, нарсан ойд амьдардаг.
3. Төрөл бүрийн жимс, самар ургамлын үр, шавьж, нахиа, шилмүүсээр хооллож амьдарна. Хаврын цагт яргуйгаар хооллодог.
4. Эр шувууны бие бүхэлдээ хар зүстэй ба далавч болон сүүлний дээд талдаа тод цагаан толбонуудтай. Хошуу хар, сүүл шулуун урт, нүдний зовхи тод улаан. Хөл бүхэлдээ өдөөр хучигдсан.
5. Тахианы өндөгний хэртэй 6-8 өндөгийг 6-р сард гаргадаг.
6. Үржлийн үедээ эр нь гоё дуу авай гаргаж сүүлээ тогос шиг цацруулж бүждэг.
7. Сойр нь шилмүүст модны торгон үзүүрийн найтагыг идэж модыг салаа болгож ургах нөхцөлийг бүрдүүлдэг.

ЦУНБХТ-ИЙН АКВАРИУМ 8 ЗҮЙЛИЙН ЗАГАСТАЙ

Монгол оронд 75 зүйлийн загас бүртгэгдсэн. “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн аквариумд гол нуурын загасыг үзмэрийн зориулалтаар тэжээж, олон нийтэд үзүүлдгээрээ онцлогтой. Жижиг жараахайнаас авхуулаад хамгийн том загас болох тулыг хүртэл олон нийтэд үзүүлж, таниулан сурталчилдгаараа экологийн боловсролын чухал ач холбогдолтой билээ.



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

**ХААН ЗАГАСНЫ
ТУХАЙ 18 БАРИМТ**

ТУЛ

ЛАТИН НЭР: *НУСНО ТАИМЕН*

1. Тул загас амьдарч байгаа усыг ямар ч эргэлзээгүйгээр хамгийн цэнгэг, хүчилтөрөгчөөр баялаг ус гэж үздэг. Иймээс тул загасыг цэнгэг усны үзүүлэлт (indicator) гэж үздэг.
2. Хүчилтөрөгчийн агууламж ихтэй усанд тул загас 50-60 жил насалдаг.
3. Монгол орны загасны хаан загас гэгддэг тул загас нь хулд овгийн загасны хамгийн том нь бөгөөд 2.1 метр урттай, 45 кг хүртлээ томорно.
4. Монгол орны Сэлэнгэ мөрний томхон цутгал голууд, Дархадын хотгорын зарим нуур, Шишгэд, Хөг, Дэлгэрмөрөн, Эг, Онон, Хэрлэн, Халх гол, Буйр нуурт тархсан. Онон, Хэрлэн голын хэсэгчилсэн нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан. Монголд 1.8 метр урт, 40-45 кг жинтэй тул загас дайралдаж байсан.
5. Бүс нутгийн зэрэглэлээр устаж болзошгүй ангилалд орсон тул загасыг Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн, Монгол Улсын улаан номонд орсон.
6. Гайхамшигт ховор энэ загасыг бариад буцааж тавих (загасчлалын Flyfishing төрөл) гэсэн жуулчид Монгол орныг зорьдог. Тул загасыг барьсан бол загалмайг оролдолгүй, хуурай газарт хүргэлгүйгээр толгойг нь усны урсгал сөргүүлэн хөвөх боломжтойгоор буцаан тавихыг зөвлөдөг.
7. Тулын нуруу хүрэвтэр бараан, хажуу тал зэсэн улаан хүрэн, өөхий мөнгөлөг цагаан өнгөтэй. Сүүлний сэлүүр нь тод улаан өнгөтэй. Үржлийн үед нь бие нь зэсэн улаан өнгөтэй болно.

8. Амьдралынхаа ихэнх хугацаанд загас идэштэй учир экосистемийн идэш тэжээлийн гинжин хэлхээний хамгийн дээр байрлах хамгийн том махчин загас юм. Биеийн хэмжээ томрох тусам гүн ус хайж нүүдэллэдэг.
9. Долоон насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Жилийн 5-р сарын дундаас ус 10 хэм дулаан болоход голоо өгсөн ширүүн урсгалтай хайрга чулуун ёроол бүхий хэсэгт үржинэ.
10. Үржлийнхээ үед хос үүсгэнэ. Үржлийн хосууд 1 метр хүртэлх гүнд 20-30 см гүнзгий үүр ухан түрсээ шахна. Атуу багадаа 8500 орчим, түүнээс дээш 30 мянга хүртэлх тооны түрс гаргана. Бие нь томрох тусам гаргах түрсний тоо олширно.
11. Уулын ширүүн урсгалтай, хүйтэн, тунгалаг, хүчилтөрөгчөөр баялаг голын усанд амьдрах зохилдолгоотой. Голын гүнзгий булан тохой, цүнхээлд өвөлжиж, хаваржина.
12. Залуу тул усны элдэв сээр нуруугүйтэн амьтдаар хооллож байгаад 4 наснаасаа махан идшинд шилжин загас, жижиг хөхтөн, шувууны ангаахай, дэгдээхий барьж иднэ.
13. Өвөлжөө, хаваржааных нь амьдрах орчин болсон цүнхээл газрыг хөндөн сүйтгэх, усны бохирдол, хууль бус агнуур зэрэг нь тул загасны тоо толгойг цөөрүүлж байгаа гол шалтгаан
14. Тул загасны тархалт 1985 оноос хойш 60 орчим хувиар буурсан гэж судалгаагаар гарсан.
15. Зөвхөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага / БОАЖЯ/-ын тусгай зөвшөөрлөөр эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар бариад буцаан тавьдаг хуультай
16. Тул загасны экологи-эдийн засгийн үнэлгээг 408 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд хууль бусаар агнах, барих тохиолдолд уг үнэлгээг 2 дахин нугалж төлдөг хуультай.
17. Усны бохирдол, голын гольдирол гаднын механик нөлөөгөөр өөрчлөгдөх, усны түвшин буурах, хууль бус агнуур зэрэг нь тул загасны тархалт, тоо буурах үндсэн шалтгаан болсон.
18. “Амьтны тухай” хуульд зааснаар жил бүрийн 10 дугаар сарын 30 -ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл тул загасыг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар амьдаар нь барихыг хориглосон.



ШИВЭР СУГАС



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР: SIBERIAN DACE

ЛАТИН НЭР: LEUCISCUS BAICALENSIS/

Биеийн урт 22 см хүрнэ. 3-6 насандаа биеийн урт 11-14 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. Шивэр сугас усны ёроолын шавжийн авгалдай, хуурай газраас усанд унасан шавж, тэдгээрийн авгалдай, замгаар хооллоно.

МОРИН ГҮРЦ



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР : DOG FACED GUDGEON

ЛАТИН НЭР: GOBIO GOBIO CYNOCERPHALUS

Биеийн урт 20 см хүрнэ. Морин гүрцийн жараахай ёроолын жижиг сээр нуруугүйтэн амьтдаар хооллодог бол бие гүйцсэн нь жингэнүүр ялааны авгалдай, өдөрч шавжийн авгалдай, жижиг зөөлөн биетэн, хавартаа бусад загасны түрсээр хооллоно.

САХАЛТ ЭРЭЭЛЖ



АНГЛИ НЭР : SIBIRIAN STONE LOACH

ЛАТИН НЭР: BARBATULA TONI

Ам 3 хос сахлаар хүрээлэгдсэн. Биологийн онцлог шинж нь биеийн урт 11 см хүрнэ. Харьцангуй хүйтэн усны загас. Ихэнхдээ өндөрлөг газрын чулуу хайрган ёроолтой хэсэгт амьдарна.

АМАРЫН ХӨӨЛӨНХЭЙ



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

МӨНГӨЛӨГ ХЭЛТЭГ



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР : PRUSSIAN CARP

ЛАТИН НЭР: CARASSIUS GIBELIO

Биологийн онцлогийн хувьд биеийн урт 45 см, жин 1.0 кг хүрнэ. Хүчилтөрөгчийн дутагдалтай, бага зэргийн бохирдсон усанд амьдрах чадвартай.

ЕРДИЙН ВАРЛАН



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР : ERASION MINNO

ЛАТИН НЭР: PHOXINUS PHOXINUS

Ердийн варлангийн биеийн урт 8-9, заримдаа 12.5 см хүрнэ. Нуур голын түргэн урсгалтай хэсэг, эргийн дагууд амьдарна. Ердийн варлан ихэвчлэн сүрэг үүсгэдэг, маш их хөдөлгөөнтэй загас.

БУЛУУ ЦАГААН



“ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ”-ИЙН АМЬТНЫ
МУЗЕЙН ҮЗМЭРЭЭС...

АНГЛИ НЭР : AMUR CARP

ЛАТИН НЭР: CYPRINUS CARPIO НАЕМАТОПТЕРУС

Биологийн онцлогийн хувьд биеийн урт 1 метр, жин 16 кг хүрнэ. Орхон голын эргийн 30-60 см гүнтэй ээвэр дулаан булан, тохойд булуу цагаан загас сүрэглэн идээшилнэ.

АНГЛИ НЭР : STONE NOROKO

ЛАТИН НЭР: PSEUDAROSBORA PARVA

Биологийн онцлогийн хувьд амарын хөөлөнхэй нь биеэр жижиг, сүрэглэн амьдардаг агнуурын бус загас юм. Биеийн урт 8 см хүрнэ. Амарын хөөлөнхэй намуун дөлгөөн усны амьдралтай, өвлийн цагт хөдөлгөөний идэвхигүй. Голын тогтуун урсгалтай, элс-шаварлаг ёроолтой, ургамал бүхий хэсгээр зонхилон амьдарна

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ, ЭХ СУРВАЛЖ

1. Баасанжав Г., Цэнд-Аюуш Я. “Монгол орчны загас”: Улаанбаатар хот, 2001 он. 176 хуудас.
2. Баасанжав Г. Дорнод Монголын загасны зүйлийн бүрэлдэхүүн, экологи. “Дорнод Монголын экосистем” бүтээлийн 1 дүгээр дэвтэр, Улаанбаатар хот, 2001 он.
3. Васильченко А.А. Птицы Хамар-Дабана: Новосибирск: Издательство “Наука” сибирское отделение, 1987г. – 96с.
4. Гагина Т.Н. Птицы Новые данные о распространении птиц в Восточной Сибири // Орнитология, 1960г, - Вы.3. – 225с.
5. “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийн олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (CITES)-ийн лавлах”: Улаанбаатар хот, 2018 он.
6. Gombobaatar S. “BIODIVERSITY OF MONGOLIA”: Names, Distribution and Identification of Vertebrate Species, Ulaanbaatar 2019.
7. Цэвэгмид Д., Цэнджав Д. “Монгол орны хөхтөн амьтан”: Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар хот, 1988 он. 186 хуудас.
8. “Монгол орны биологийн олон янз байдал”: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт, Тэргүүн боть, – ISBN 978-9919-9518-1-8.
9. “Монгол орны шувууд”: (гэрэл зурагт лавлах), Улаанбаатар хот 2019 он.
10. “Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага” (Гутгаар хэвлэл).
11. “Монгол улс ба зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай КОНВЕНЦ”: Монгол улс, Улаанбаатар хот, 2019 он.
12. “Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд”: (Нэмж засварласан дөрөв дэх хэвлэл), Улаанбаатар хот, 2012он.
13. “Хууль, журам, аргачлал, загварын эмхэтгэл”: Улаанбаатар хот, 2021 он.
14. http://touristinfocenter.mn/cate11_more.aspx?ItemID=139
15. https://mn.wikipedia.org/wiki/Идлэг_шонхор
16. <https://shiliinbogd.blogspot.com/2012/12/blog-post.htm>
17. <http://www.mglnews.mn/content/read/52621.htm>
18. <https://www.arav.mn/n/xv>
19. http://www.touristinfocenter.mn/cate10_more.aspx?ItemID=36
20. <https://mn.wikipedia.org/wiki>